



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/652

Булган сум

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын 3.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2024 оны 152 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжаар батлагдсан төсвийн орлогын хуваарийг 1 дүгээр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хуваарийг 2 дугаар, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн хуваарийг 3 дугаар, сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хуваарийг 4 дүгээр, орон нутгийн төсвөөс санхүүжих байгууллагуудын сарын хуваарийг 5 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2. Санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

